

## МОНГОЛЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН ХОЛБООНЫ 2018-2023 ОНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

Монголын Барилгын зураг төсөл зохиогчдын холбооны 2018-2023 оны хөгжлийн стратегийг боловсруулахдаа “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”, “Барилгын тухай хууль” Холбооны дүрэм зэрэг баримт бичгүүд, Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшил, бүс нутаг, хот байгуулалт, барилгын зураг төслийн өнөөгийн байдал, төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зорилтуудыг тодорхойлов.

### Нэг. Өнөөгийн байдал, үндэслэл

“Барилгын тухай” Монгол Улсын хууль нь 2016 оны 2 дугаар сард шинэчилсэн найруулгаар батлагдсан бөгөөд тухайн хуулинд барилгын зураг төсөлд тавигдах шаардлага, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болохоор хуульчилсан. Мөн тус холбоо нь “Төрийн бус байгууллагын тухай” хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаар анх 2007 оны 06 сарын 07-ны өдөр үүсгэн байгуулагдсан.

Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх хэсэг, 23 дугаар зүйл, 25 дугаар зүйл, 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.8, 33 дугаар зүйлийн 33.1.3, 33.1.9, 33.1.12, 33.1.13, 33.1.14, 33.1.21, 34 дүгээр зүйлийн 34.2, 36 дугаар зүйл, 38 дугаар зүйл, 39 дүгээр зүйл, 42 дугаар зүйл, 44 дүгээр зүйлүүд нь Холбооны үйл ажиллагаа болон гишүүн байгууллагуудын тогтвортой үйл ажиллагаа явуулах, эрх ашгийг хамгаалах, хамтын ажиллагааг дэмжих, төрийн байгууллагын үндсэн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх эрх зүйн орчинтой болсон.

Хууль эрх зүйн хүрээнд орсон эдгээр нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгууд нь төрийн хяналт, мэдээлэл, үйлчилгээ, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулах, барилга, байгууламжийн зураг төслийн үйл ажиллагаатай холбогдон гарах сайжруулалт, зураг төслийн чанарыг сайжруулах, гадаад улсын зураг төслийг баталгаажуулалтын зохион байгуулалтыг хангах эрх зүйн зохицуулалт бий болсон гэж үзэж байна.

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:



Б.Оюунбилэг/  
Г.Мягмар/  
М.Амаржаргал/


МОНГОЛЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН ХОЛБООНЫ  
АЛСЫН ХАРАА

---

*Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, салбарын манлайлагч, төрийн бус, мэргэжлийн байгууллага байна.*

---

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:



/Б.Оюунбилэг/  
/Г.Мягмар/  
/М.Амаржаргал/

## МОНГОЛЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН ХОЛБООНЫ ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооны эрхэм зорилго нь:

*Хот байгуулалт, барилгын зураг төслийн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогыг төр болон төрийн бус, мэргэжлийн байгууллагын түншлэлийг хөгжүүлэх замаар хэрэгжүүлэх, зураг төслийн ажлыг олон улсын жишигт хүргэх, төрийн ногоон хөгжлийн бодлогыг дэмжих, гишүүн байгууллагын түвшинг дээшлүүлэх, инженер, техникийн ажилчдын чадавхийг хөгжүүлэх, мэдээллээр хангаж эрх ашгийг хамгаалахад оршино.*

Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооны эрхэм зорилгыг биелүүлэхэд чиглэсэн дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

### ЗОРИЛТ 1. (Нөлөөлөл)

Хот байгуулалт, зураг төслийн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогод санал өгөх, төр болон төрийн бус байгууллагын түншлэлийг хөгжүүлэх замаар гишүүн байгууллагуудын эрх ашгийг хамгаалах, тогтвортой хөгжлийг хангах;

### ЗОРИЛТ 2. (Идэвхжүүлэлт)

Хот байгуулалт, зураг төслийн салбарын хууль эрх зүйн баримт бичиг, нормативын баримт бичгийг сайжруулах замаар салбарын шинэ мэдээ мэдээллээр хангах, мэргэшлийн ерөнхий чадавхийг болон ногоон барилгын төлөвлөлтийн чадавхийг дээшлүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан архитектур, хот байгуулалт, барилгын зураг төслийн асуудлаар нийгмийн боловсролыг сайжруулах;

### ЗОРИЛТ 3. (Хөрөнгө оруулалт)

Холбооны үйл ажиллагааг тогтвортой явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлэх замаар бий болгох;

### ЗОРИЛТ 4. (Хамтын ажиллагаа)

Хот байгуулалт, зураг төслийн салбарт гадаадын ижил төрлийн байгууллагатай хамтын ажиллагаа тогтоох, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх, төрийн байгууллагаас шилжүүлсэн чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагад гэрээний үндсэн дээр гүйцэтгэх, бусад төрийн бус, мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг дээшлүүлэх;

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:



/Б.Оюунбилэг/  
/Г.Мягмар/  
/М.Амаржаргал/

## МОНГОЛЫН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН ХОЛБООНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2018-2023)

| д/д  | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа  | Хугацаа   | Хариуцах эзэн                            | Хүрэх үр дүн  |
|--|--|-----------|--|---|
| ЗОРИЛТ 1. Хот байгуулалт, зураг төслийн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогод санал өгөх, төр болон төрийн бус байгууллагын түншлэл хөгжүүлэх замаар гишүүн байгууллагуудын эрх ашгийг хамгаалах, тогтвортой хөгжлийг хангах; |  |           |  |   |
| 1.1  | Хот байгуулалт, зураг төслийн салбарын хууль эрхзүйн орчныг сайжруулахад чиглэгдсэн дүрэм журамд санал өгөх  |           |  |   |
|  | - Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам  | 2018      | Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ажлын алба | Олон улсын байгууллага, гадаадын норм дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх үйл ажиллагаа сайжирна.   |
|  | - Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах барилга, байгууламжийн зориулалт, хүчин чадалыг тогтоох  | 2018      | Дэд ерөнхийлөгч, Ажлын алба              | ТЗ-ийн ажилбарын төрөл, мэргэшсэн, зөвлөх архитектор инженерүүдийн эзэмшвэл зохих мэргэжлийн ур чадварын түвшин, магадлалын шалгуур үзүүлэлт, хүрээ тодорхой болно. |
|  | - Хот байгуулалт, зураг төслийн үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдэд энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан ангилалын дагуу тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, бүртгэх журам | 2018      | Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ажлын алба | Тусгай зөвшөөрлийн материал бүрдүүлэх, хүлээж авах, бүртгэх үйл ажиллагаа сайжирна.   |
|  | - Эрх бүхий гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан барилга байгууламжийн зураг төслийг баталгаажуулахад тавих шаардлага  | 2018-2019 | Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ажлын алба | Гадаадын зураг төслийг баталгаажуулахад тавих шаардлагыг олон улсын зураг төсөл боловсруулах үе шатанд нийцүүлснээр зураг төслийн ойлголтын зөрүү арилна.           |
|  | - барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо  | 2018      | Ерөнхийлөгч, Ажлын алба                  | Норм нормативын ерөнхий тогтолцоо сайжирна.   |
|  | - барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм  | 2018      | Ерөнхийлөгч, Ажлын алба                  | Барилга байгууламжийн ЗТ боловсруулах, магадлал хийх үйл ажиллагаа сайжирна.  |
|  | - барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам;  | 2018      | Ерөнхийлөгч, Ажлын алба, УЗ              | Зургийн экспертэд тавих шаардлага, экспертиг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох үйл ажиллагаа сайжирна.   |
|  | - барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн журам  | 2018      | Ерөнхийлөгч, Ажлын алба                  | Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагаа сайжирна.   |
|  | - архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам   | 2018      | Ерөнхийлөгч, Ажлын алба                  | Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа сайжирна.  |
|  | - барилга байгууламжийн цахим тооцооллын программ хангамжийг   | 2018      | Ерөнхийлөгч, Ажлын алба                  | Зураг төсөлд тооцооны программыг баталгаажуулж  |

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:

Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:



/Б.Оюунбилэг/

/Г.Мягмар/

/М.Амаржаргал/

|     |  |           |  |  |
|-----|--|-----------|--|--|
|     | баталгаажуулж, хэрэглэх журам  |           |  | хэрэглэх үйл ажиллагаа сайжирна.   |
|     | - барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах журам  | 2018      | Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ажлын алба                 | Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажил сайжирна.  |
|     | - барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам | 2018      | Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ажлын алба, Удирдах зөвлөл | барилга байгууламжийн ЗТ боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, БМ үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд ТЗ олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих үйл ажиллагаа сайжирна. |
|     | - барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм   | 2018      | Ерөнхийлөгч, Ажлын алба                                  | Барилгын ажилд тавих зураг төсөл зохиогчийн хяналт сайжирна.   |
|     | - Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журм   | 2018      | Ерөнхийлөгч, Ажлын алба                                  | Зөвлөх үйлчилгээний үйл ажиллагаа сайжирна.  |
| 1.2 | Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг гэрээний үндсэн дээр зохион байгуулах ажлууд  |           |  |  |
|     | - Барилгын зураг төсөл боловсруулах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээгээр зохион байгуулах   | 2018      | Ерөнхийлөгч, ДЕ, АА                                      | Барилгын зураг төсөл боловсруулах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээгээр зохион байгуулна   |
|     | - зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх   | 2018      | Ажлын алба   | зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэлтэй болно.  |
|     | - архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг нь зохион байгуулах   | 2018      | Ерөнхийлөгч, Ажлын алба                                  | архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.  |
|     | - барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах   | 2018      | Ерөнхийлөгч, ДЕ, АА                                      | барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг тогтмолжуулна.   |
| 1.3 | Холбогдох зөвлөл, ажлын хэсэгт холбоог төлөөлөн оролцож гишүүн байгууллагуудын ашиг сонирхолыг тусгаж ажиллах  |           |  |  |
|     | - Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөл  | 2018-2023 | Ерөнхийлөгч  | БХБ-ын сайдын зөвлөлд холбоог төлөөлөн оролцож, гишүүн байгууллагуудын ашиг сонирхолыг тусгана.  |
|     | - Шинжлэх ухаан, технологи, ногоон хөгжлийн бодлогын зөвлөл  | 2018-2023 | Ерөнхийлөгч  | ШУТ, ногоон хөгжлийн бодлогын зөвлөлд холбоог төлөөлөн оролцож, холбооны саналыг тусгана.  |
|     | - Архитектур, инженерийн мэргэжлийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл   | 2018-2023 | Ажлын алба   | Архитектур, инженерийн мэргэжлийн ОТБМЗ-д холбоог төлөөлөн оролцож, саналыг тусгана.   |
|     | - Ногоон барилгын зөвлөл   | 2018-2023 | Ерөнхийлөгч  | Ногоон барилгын зөвлөлд холбоог төлөөлөн оролцож,  |

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:



/Б.Оюунбилэг/  
/Г.Мягмар/  
/М.Амаржаргал/

|  |  |           |                         |   |
|--|--|-----------|-------------------------|---|
|  | - Стандартчилалын техникийн хороод (ТХ22, ТХ11/ДХ01)   | 2018-2023 | Дэд ерөнхийлөгч         | холбооны саналыг тусгана. Стандартчилалын техникийн хороо (ТХ22, ТХ11/ДХ01) –д холбоог төлөөлөн оролцож, холбооны саналыг тусгана.                                |
| ЗОРИЛТ 2. Хот байгуулалт, зураг төслийн салбарын хууль эрх зүйн баримт бичиг, нормативын баримт бичгийг сайжруулах замаар салбарын шинэ мэдээ мэдээллээр хангах, мэргэшлийн чадавхийг дээшлүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх; |  |           |                         |   |
| 2.1  | "Барилгын норм, норматив боловсруулах сан"-гийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан норм, нормативын баримт бичгийг боловсруулах ажлыг зохион байгуулах, гишүүн байгууллагуудыг татан оролцуулах | 2018-2023 | Ерөнхийлөгч, Ажлын алба | Норм нормативын баримт бичгийг сайжруулна.  |
| 2.2  | Хот байгуулалт, зураг төслийн баримт бичгийн төрөл, боловсруулах үе шат, хянаж баталгаажуулах үе шатыг боловсронгуй болгох   | 2018      | Ерөнхийлөгч, Ажлын алба | Хот байгуулалт, зураг төслийн баримт бичгийн үе шат, хянаж баталгаажуулах үе шатыг гадаад оронд түгээмэл хэрэглэдэг зураг төсөл боловсруулах үе шаттай нийцүүлнэ. |
| 2.3  | Шинээр батлагдсан норм, нормативын баримт бичгийг сурталчлах, танилцуулах сургалтыг зохион байгуулах замаар гишүүн байгууллагын инженер, техникийн ажилтны мэргэшлийн чадавхийг сайжруулах         | 2018-2023 | Ерөнхийлөгч, Ажлын алба | Инженер, техникийн ажилтны мэргэшлийн чадавхи сайжирна.   |
| 2.4  | Зураг төслийн үндсэн шийдэлд шинжлэх ухаан технологийн ололтыг нэвтрүүлэхийг дэмжиж, гишүүн байгууллагад мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр хангах   | 2018-2023 | Ерөнхийлөгч, Ажлын алба | Зураг төслийн үндсэн шийдэл сайжирна.   |
| 2.5  | Гишүүн байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт өгч, тогтвортой үйл ажиллагаа явуулах дэмжлэг үзүүлэх   | 2018-2019 | Ерөнхийлөгч, Ажлын алба | Гишүүн байгууллагуудын үйл ажиллагаа сайжирч тогтвортой болно.  |
| 2.6  | Хот байгуулалт, зураг төслийн салбарын мэдээллээр гишүүн байгууллагуудыг хангах  | 2018-2023 | Ажлын алба              | Хот байгуулалт, зураг төслийн салбарын мэдээллээр гишүүн байгууллагуудыг хангана.   |
| 2.7  | Нийгэмд тустай үйл ажиллагаанд идэвхтэй оролцох  | 2018-2023 | Ажлын алба              | Нийгэмд тустай үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.   |
| ЗОРИЛТ 3. Холбооны үйл ажиллагааг тогтвортой явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлэх замаар бий болгох;   |  |           |                         |   |
| 3.1  | Гишүүн байгууллагын гишүүнчлэлийн татвар, хандивыг уян хатан байдлаар төвлөрүүлэх  | 2018-2023 | Ажлын алба              | Гишүүн байгууллагын гишүүнчлэлийн татвар, хандивыг төвлөрүүлнэ.   |
| 3.2  | Үйл ажиллагааны хүрээнд зохион   | 2018-     | Ажлын алба              | Үйл ажиллагаанаас орох  |

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:



/Б.Оюунбилэг/  
/Г.Мягмар/  
/М.Амаржаргал/

|   |   |           |  |  |
|---|---|-----------|--|--|
|   | байгуулж буй сургалт семинар, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсэн орлогыг нэмэгдүүлэх   | 2023      |  | орлогыг нэмэгдүүлнэ  |
| 3.3   | Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар орлогоо нэмэгдүүлэх   | 2018-2023 | Ажлын алба                               | Холбооны орлогоо нэмэгдүүлнэ   |
| 3.4   | Санхүүгийн биет бус оюуны хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны дэмжлэгийг нэмэгдүүлэх   | 2018-2023 | Ажлын алба                               | Санхүүгийн биет бус оюуны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ                               |
| <b>ЗОРИЛТ 4.</b> Хот байгуулалт, зураг төслийн салбарт гадаадын ижил төрлийн байгууллагатай хамтын ажиллагаа тогтоох, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх, төрийн чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагад гэрээгээр гүйцэтгэх, бусад төрийн бус, мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг дээшлүүлэх; |   |           |  |  |
| 4.1   | Салбарын төрийн бус байгууллагуудтай хамтран Төрийн бус байгууллагын эрх ашгийг хамгаалах, хамтын ажиллагааг дээшлүүлэх                             | 2018-2023 | Ерөнхийлөгч, Ажлын алба                  | Салбарын төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг дээшлүүлнэ.                     |
| 4.2   | Ижил төстэй гадаадын байгууллагатай хамтран ажиллах үндсэн чиглэлийг тогтоож хамтын ажиллагааг ахисан түвшинд гаргах                                | 2018-2023 | Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ажлын алба | Ижил төстэй гадаадын байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулна.                      |
| 4.3   | Гишүүн байгууллагуудыг гадаадын ижил төрлийн байгууллагатай холбоо тогтоох, үйл ажиллагаагаа танилцуулах хамтын ажиллагааг дээшлүүлэх дэмжин туслах | 2018-2023 | Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ажлын алба | Гишүүн байгууллагуудын гадаадын ижил төрлийн байгууллагатай хамтын ажиллагаа дээшилнэ. |
| <b>Бусад</b>  |   |           |  |  |
| 5.1   | Холбооны хороодын үйл ажиллагааг сэргээж ажиллуулах   | 2018-2023 | Ерөнхийлөгч, Ажлын алба                  | Холбооны хороодын үйл ажиллагаа сайжирна.  |
| 5.2   | Холбооны үйл ажиллагааны дүрэм журмыг шинэчлэх  | 2018-2023 | Ерөнхийлөгч, Ажлын алба                  | Холбооны үйл ажиллагаа сайжирна  |

--o---0---o--

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:



/Б.Оюунбилэг/  
/Г.Мягмар/  
/М.Амаржаргал/

SWOT шинжилгээ  
Differentiating values

|             | <b>S</b>  | <b>W</b>   | <b>O</b>  | <b>T</b>   |
|-------------|---|--|---|--|
| <b>2018</b> | <p><b>Давуу тал</b><br/>Strengths</p> <ul style="list-style-type: none"> <li>-Идэвхтэй үйл ажиллагаатай 130 гаруй гишүүнтэй</li> <li>-Зураг төслийн чиглэл тус бүрээс төлөөлөлтэй</li> <li>-Салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн</li> <li>-Салбарын зөвлөл, ажлын хэсэгт төлөөлөлтэй</li> </ul>   | <p><b>Сул тал</b><br/>Weaknesses</p> <ul style="list-style-type: none"> <li>-Гишүүнчлэлийн тоо буурч идэвх суларч байгаа</li> <li>-Санхүүгийн бололцоо сул</li> <li>-Гадаад харилцаа байхгүй</li> <li>-МУ-ын зураг төслийн үе шат ОУ-ын стандарттай зөрчилтэй</li> </ul> | <p><b>Боломж</b><br/>Opportunities</p> <ul style="list-style-type: none"> <li>-Салбарын оюуны потенциал өндөр</li> <li>-Залгамж чанар хадгалагдсан</li> <li>-Төрийн бодлого нь ТББ-уудаа дэмжиж байгаа</li> </ul>   | <p><b>Эрсдэл</b><br/>Threats</p> <ul style="list-style-type: none"> <li>-ТББ-ууд хоорондоо харилцан ойлголцолгүй байх</li> <li>-Төрийн яамдын бодлого, удирдлага тогтвортой биш, мэргэжлийн удирдлага дутмаг</li> <li>-Бодлогын бичиг баримтын шинэчлэл удаан</li> </ul> |
| <b>2023</b> | <p><b>Давуу тал</b><br/>Strengths</p> <ul style="list-style-type: none"> <li>-Мэргэжлийн ур чадвар дээшилсэн гишүүдийн тоо нэмэгдэнэ</li> <li>-Зураг төслийн салбарыг техникийн удирдлага зохион байгуулалтаар хангах чиглэл баримталсан байна.</li> <li>-Салбарын зөвлөл ажлын хэсгийн төлөөлөлийн ур чадвар мэргэшсэн байна.</li> </ul> | <p><b>Сул тал</b><br/>Weaknesses</p> <ul style="list-style-type: none"> <li>-Гадаад харилцаанд холимог зураг төслийн ТББ байгууллага байхгүй учраас аль нэг мэргэжлийн гадаад харилцаа суларсан байна.</li> </ul>  | <p><b>Боломж</b><br/>Opportunities</p> <ul style="list-style-type: none"> <li>-Мэргэжлийн сургалтын төв бий болох</li> <li>-Засгийн газрын бодлого чиглэлд салбарын бодлогыг тодорхойлоход төрийн байгууллагатай хамтрах боломж бүрдсэн байна.</li> </ul> | <p><b>Эрсдэл</b><br/>Threats</p> <ul style="list-style-type: none"> <li>-Тухайн үеийн ЗГ-ын мөрийн хөтөлбөрт дэмжих бодлого тусахгүй</li> </ul>  |

МБЗТЗХ-ны Бүх гишүүдийн хурлын дарга:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:  
Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгч:



/Б.Оюунбилэг/  
/Ф.Мягмар/  
/М.Амаржаргал/